БАТЛАВ

ЗДТГ-ЫН ДАРГА Д. СОНИНБАЯР

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ХАРТОЙРОМ БАГИЙН ТӨВИЙН БАРИЛГЫГ ШИНЭЭР БАРИХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Үндэслэл	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 2/17 дугаар тогтоол
1	Захиалагч	Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГазар
2	Зориулалт	Хартойром багийн төвийн барилгыг шинээр барих
3	Хийгдэх ажил	Багийн төвийн барилга барих ✓ Барилгын: Урт 12 метр, Өргөн 9 метр ✓ Хана: Хананы өндөр шалнаас тааз хүртэлх зай 2,4 метр. Хайрган блокоор өрж, 5см-ийн хөөсөөр дулаалж, тоосгоор өнгөлнө. Дотор хананд тэгшилгээ шавар хийж дотор эмульсээр будна. ✓ Вакум цонх 6 ширхэг байна. Хэмжээ: 4 ширхэг цонх нь өргөн 160 см, өндөр 140 см , 2 ширхэг цонх нь өргөн 120 см өндөр 140 см. Цонх тус бүр төмөр хамгаалалттай байна. ✓ Хаалга: сайн чанарын /бүргэд хаалга/ 2 ширхэг, /модон хаалга/ 2 ширхэг ✓ Дээвэр: Мэлхий нуруутай, төмөр дээврийг унь банз, эсвэл хавтан ашиглаж тогтоож бэхэлнэ. Дээврийн хар таазан дээр таваарын бүтээлэг бүтээж шилэн хөвөн дэвсэж, шилэн хөвөнг мөн таваарын бүтээлгээр бүтээнэ. ✓ Дотор тааз: 12 мм-ийн сайн чанарын гипсэн хавтангаар доторлож, 40 см тутамд шрүфдэж тогтооно. Мөн хар торлож, хар замаск татаж эмульсдэнэ. ✓ Шал: Цемент /цутгамал хийж /, сайн чанарын хулдаасыг наана. ✓ Халаалт: Түлшинд хэмнэлттэй бүрэн шаталттай сайн чанарын төслийн зуух буюу Хас зуух байна. Янданг байшингийн өндөрт тохируулан хийнэ. ✓ Үүдний гишгүүр: цутгамал 150х150 см2, барилгын 4 талд 50 см-ийн өргөн, 10-15 см зузаантай хаяавчийг цементээр цутгана. ✓ Тогны далд монтаж хийж гадна хананд хүчдэл залгах разетка суурилуулсан байна.
4	Ажилд хэрэглэгдэх барилгын материалын шаардлага	✓ Ашиглагдаж байгаа барилгын материал нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байх ✓ Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлыг хангасан байна. ✓ Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Ажлын үе шат	1. Ажлын даалгавар зураг төсөв 2. Тендер сонгон шалгаруулалт 3. Гүйцэтгэлийн хяналт шалгалт

		4. Нийлүүлэх, хүлээлгэн өгөх

-oOo-

ХАР ТОЙРОМ БАГИЙН ТӨВИЙН БАРИЛГЫН ЗУРАГ